

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04-р сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

“Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 23-ны өдрийн 09:45 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, “Номин юнайтед” төвийн 4.5 дугаар давхарт танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 4 хувьцаа эзэмшигч цахимаар оролцсон боловч 2 хүн санал өгсөн.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 13-ны өдрийн 26/04 дугаартай тогтоолоор томилогдсон хурлын дарга Я.Наваан, тооллогын комиссын дарга, эдийн засагч Г.Өсөхбаяр, тооллогын комиссын гишүүн хуульч Г.Энхзаяа, нягтлан бодогч Н.Сүрэнжав, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат нарын бүрэлдэхүүнтэйгээр хурлын үйл ажиллагааг зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зард тусгасны дагуу хуралд биечлэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн иргэний цахим үнэмлэх, бичиг баримтыг шалгасны үндсэн дээр Тооллогын комисс хурлын ирцийг бүртгэх ажлыг 08:45 цагаас 09:45 цаг хүртэл хугацаанд хийв.

Хурлын үйл ажиллагааг 09:45 цагт эхлүүлэв.

Хурлын дарга Я.Наваан: “Улсын их дэлгүүр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 23-ны өдөр биечилсэн болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 13-ны өдрийн хурлаас гаргасан. Хуралд цахим хэлбэрээр 2 хувьцаа эзэмшигч, бусад нь танхимд биечлэн оролцож байна. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах эрхийг ТУЗ-ийн дарга Я.Наваан надад олгосон. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг Г.Өсөхбаяр, Г.Энхзаяа, Н.Сүрэнжав гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Ингээд “Улсын их дэлгүүр” ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байгааг мэдэгдье.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг ТУЗ-өөс баталсныг та бүхэнд танилцуулъя.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
2. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах.

Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. Тооллогын комисс хурлын бүртгэл хийж, ирц танилцуулах ажлыг хийнэ. Үүний дараа хурлын дарга миний бие хурлаар хэлэлцэх 2 асуудалтай холбоотой танилцуулгыг та бүхэнд хүргэнэ. Дараа нь ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулна. Дараа нь хувьцаа эзэмшигчдээс үг хэлэх, санал гаргах үе шат эхэлнэ. Дараа нь хурлаар хэлэлцсэн асуудалд саналын хуудсаар санал хурааж, тооллогын комисс санал хураалтын үр дүнг танилцуулж, хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулснаар хурлын үйл ажиллагаа дуусна. Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Өсөхбаяр: Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 25,958,665 ширхэг хувьцааны саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу компанийн нийт хувьцааны 70.52%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцож байгаа учраас Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хурлын ирцийг хүчинтэйд тооцож байна.

Нийт 58 хувьцаа эзэмшигч урьдчилан саналын хуудсаар саналаа өгснийг хурлын ирцэд оруулан тооцсон болно. Хуралд 43 хувьцаа эзэмшигч биечлэн оролцож байна.

Хурлын дарга Я.Наваан: Хурлын ирц бүрдсэн учраас хурлын үйл ажиллагааг эхлүүлэе. Хурлаар хэлэлцэх нэгдүгээр асуудал буюу компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах асуудалд оръё. Компанийн үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга миний бие танилцуулъя. Хувьцаа эзэмшигчдэд энэхүү мэдээлэл материалыг брокерын компаниудаар дамжуулан урьдчилан хүргүүлсэн байгаа.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН НЭГДҮГЭЭР АСУУДАЛ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар:

2025 онд “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Я.Наваан, С.Хосбаяр, А.Норсмаа, Х.Эрдэнэбаатар, Т.Сарантуяа, Ж.Дөлгөөн нар, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр М.Дамирансүрэн, Н.Энхчимэг, М.Ганцэцэг нар, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар М.Өлзийбат, компанийн Гүйцэтгэх захирлаар Х.Эрдэнэбаатар нар ажиллалаа.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хэтийн төлөв, зорилтыг тодорхойлон хууль, дүрэм, журамд заасан эрх үүргийнхээ хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, түүний дэргэдэх хороод нь хорооны эрх мэдлийн хүрээнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөл тайлант хугацаанд нийт 5 удаа биечлэн хуралдаж, 4 удаа эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж, гүйцэтгэх удирдлагын шийдвэрлүүлэхээр санал оруулсан асуудлуудыг цаг тухайд нь бүрэн шийдвэрлэж ажилласан.

Компанийн санхүүгийн нөхцөл байдлын талаар:

“Улсын Их Дэлгүүр” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу түрээслэгч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр түрээсийн гэрээг 6 жилийн хугацаатай байгуулж, 2025 оны 4 дүгээр сард түрээсийн үнийг 7%-иар өсгөж, 2025 онд нийт 9,395.4 сая төгрөгийн түрээсийн орлоготой, 1,055.8 сая төгрөгийн ашигтай ажиллалаа.

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны зардал 8,250.1 сая төгрөг байна. Үйл ажиллагааны зардлын 2.6 хувийг хөдөлмөрийн зардал, 46.8%-ийг ашиглалтын зардал, 0.1%-ийг барилгын урсгал засварын зардал, 14.6%-ийг хөрөнгийн элэгдлийн зардал, 29.6%-ийг зээлийн хүүгийн зардал, 2.3%-ийг үл хөдлөх хөрөнгийн болон газрын татвар, 2.2%-ийг даатгалын зардал, 1.8%-ийг бусад зардал эзэлж байна.

Үйл ажиллагааны бус орлогын хувьд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ногдол ашиг 25.4 сая төгрөг, банкны харилцах дансанд тооцсон хүүгийн орлого 3.2 сая төгрөг, бусад орлого 2.8 сая төгрөг байна.

2025 онд нийт хөрөнгийн дүн 13,277.5 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 3.6% буюу 485.2 сая төгрөг байна. Эргэлтийн хөрөнгийн 43.6%-ийг банкны харилцах дансны үлдэгдэл, 2.7%-ийг татварын авлага, 15.7%-ийг хангамжийн материал, 38%-ийг урьдчилж төлсөн зардал буюу даатгалын зардал эзэлж бна.

Нийт хөрөнгийн дүнд эргэлтийн бус хөрөнгө 96.4% буюу 12,792.3 сая төгрөгийг эзэлж байгаагийн 71.6% буюу 9,504.8 сая төгрөгийг барилга байгууламж, 21.2% буюу 2,803.7 сая төгрөгийг машин тоног төхөөрөмж, үлдэх 3.6% буюу 483.8 сая төгрөгийг хөрөнгө оруулалт болон хойшлогдсон татварын хөрөнгө эзэлж байна.

Оны эхэнд дансны авлага 17.4 сая төгрөг, оны эцэст 13.3 сая төгрөг байна. Авлагыг ангилж үзвэл НӨАТатварын авлага 13.2 сая төгрөг, бусад авлага 0.1 сая төгрөг байна.

Оны эхэнд 1,146.4 сая төгрөгийн богино хугацаат өглөгтэй байснаас оны эцэст 481.1 сая төгрөг болсон.

Зээлийн хүүгийн өглөг 203.1 сая төгрөг, холбоотой талын өглөг 136.6 сая төгрөг, цалин, ндш, татварын өглөг 50.5 сая төгрөг, дотоодын харилцагчид төлөх өглөг 90.9 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд Голомт банкны зээлээс гэрээний дагуу 1.2 тэрбум төгрөг төлсөн байна.

“Улсын их дэлгүүр” ХК нь 2025 онд 24.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба бодит гүйцэтгэлээр 1,055.8 сая төгрөгийн ашигтай ажилласан. Ашиг өндөр гарсан шалтгаан нь ус, дулааны тарифыг өсөлттэй төлөвлөсөн боловч тариф өсөөгүй, мөн лифтний болон гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажил хийгдээгүйгээс түүнд ногдох ашиглалт, засвар, үйлчилгээний зардлууд гараагүйтэй холбоотой байна.

/Ус, дулаан, цахилгааны тарифын тооцооллоос 213.5 сая төгрөг, гэрэлтүүлгийн ажлаас 292.5 сая төгрөг, лифтний засварын ажлаас 286.0 сая төгрөг, барилгын урсгал засварын зардал 192.1 сая төгрөгний зардал гараагүй байна./

Компанийн үйл ажиллагааны талаар:

“Улсын их дэлгүүр” ХК нь татвараа үнэн зөв тодорхойлох, төлөх, тайлагнах үүргээ бүрэн биелүүлж 2025 онд ААНОАТатварт 73.5 сая төгрөг, НӨАТатварт 405.1 сая төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 185.0 сая төгрөг, ХХОАТатварт 19.2 сая төгрөг, НДШимтгэлд 28.1 сая төгрөг, газрын татварт 14.0 сая төгрөг, нийт дүнгээр 724.9 сая төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Компани 2025 онд Улсын их дэлгүүрийн барилгын зам талбайн тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх, гадна пандус засах, В1 давхрын хуучин узелийн 2 өрөөг суллаж засварлах, дэд станцын автомат болон генераторт засвар хийх, хэрэглээний халуун усны 1, 2-р хэлхээний шугам болон өргөлтийн насос солих, 6-р давхарт систем эйркондейшн суурилуулах зэрэг барилгын чанар, инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулахтай холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Дээрх засвар үйлчилгээний ажилд 221.1 сая төгрөг зарцуулжээ.

Аудитын байгууллагын зөвлөмжийн талаар:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар сонгогдсон хөндлөнгийн аудитын байгууллага “Сүлд-Аудит” ХХК-ийн зүгээс;

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэл нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/-д нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн хууль болон бусад холбогдох заавар, журмын дагуу бүх материаллаг зүйлсийг хамруулан үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн гэсэн дүгнэлт өгсөн байна.

Ингээд та бүхэнд компанийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүдийг харуулъя. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд та бүхэнд урьдчилан тараагдсан хурлын танилцуулга материалд бас орсон байгаа (гээд доорх мэдээллийг дэлгэц дээр харуулав)



СҮЛД-АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл хяналтын итгэмжлэгдсэн
байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

№ 46/09..

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Дүгнэлт

Бид “Улсын Их Дэлгүүр” Хувьцаат Компанийн (цаашид “Компани” гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.


Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СҮЛД-АУДИТ ХХК


Ч.ГҮНДБАЯР
Захирал УГК0324
ММНБ 2807000
2026 оны 2 дугаар сарын 9

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2024	12/31/2025 /төгрөгөөр/
А.ХӨРӨНГӨ			
1.Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1	47,671,547.23	211,682,055.75
Дансны авлага	2	390,000.00	39,600.00
Татвар, НДШ-ийн авлага	2	17,386,424.31	13,261,525.12
Бусад авлага		-	-
Бараа материал	3	29,441,628.47	76,057,341.45
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	4	63,846,903.22	184,162,903.25
Эргэлтийн хөрөнгийн дүн		158,736,503.23	485,203,425.57
2.Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	5	13,317,022,054.90	12,308,490,518.54
Биет бус хөрөнгө		-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	8	33,811,920.00	33,811,920.00
Хойшлогдсон татварын хөрөнгө	6	18,897,260.27	20,307,123.28
Бусад эргэлтийн бус хөрөнгө	7	558,560,700.64	429,723,094.60
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		13,928,291,935.81	12,792,332,656.42
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		14,087,028,439.04	13,277,536,081.99
Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
1.Өр төлбөр			
Дансны өглөг	9	928,554,331.13	222,141,659.22
Цалингийн өглөг	10	6,671,477.19	6,957,021.11
Татварын өр	10	5,595,409.32	31,812,373.96
НДШ-ийн өглөг	10	220,396.62	107,898.28
Хүүний өглөг	11	188,972,602.75	203,071,232.88
Ногдол ашгийн өглөг	11	15,433,581.00	15,433,581.00
Урьдчилж орсон орлого		-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	11	946,675.63	1,537,226.04
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,146,394,473.64	481,060,992.49
Урт хугацаат зээл	12	17,000,000,000.00	15,800,000,000.00
Хойшлогдсон татварын өр		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		17,000,000,000.00	15,800,000,000.00
Өр төлбөрийн нийт дүн		18,146,394,473.64	16,281,060,992.49
2.Эздийн өмч			
а.Төрийн			
б.Хувийн			
в. Хувьцаат	13	3,680,785,000.00	3,680,785,000.00
Халаасны хувьцаа	13	(175,964,106.00)	(175,964,106.00)
Нэмж төлөгдсөн капитал	13	133,351,798.00	133,351,798.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14	1,600,084,101.82	1,600,084,101.82
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	15	(9,297,622,828.42)	(8,241,781,704.32)
Эздийн өмчийн дүн		(4,059,366,034.60)	(3,003,524,910.50)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		14,087,028,439.04	13,277,536,081.99

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

		/төгрөгөөр/	
ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2024	12/31/2025
Борлуулалтын орлого (цэвэр)	16	11,038,785,569.00	9,395,405,214.57
Борлуулалтын өртөг	18	-	5,538,825,227.97
Нийт ашиг /алдагдал/		11,038,785,569.00	3,856,579,986.60
Түрээсийн орлого		-	-
Хүүгийн орлого	17	2,880,143.35	3,150,093.04
Ногдол ашгийн орлого	17	-	25,411,488.00
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	17	300,001.00	2,863,045.86
Борлуулалт, маркетингийн зардал	19	5,364,870.20	4,221,574.52
Ерөнхий ба удирдлагын зардал	19	5,582,092,641.64	242,026,950.89
Санхүүгийн зардал	20	2,111,575,342.47	2,443,912,328.91
Бусад зардал	19	99,208.82	21,108,234.07
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)		-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		3,342,833,650.22	1,176,735,525.11
Орлогын татварын зардал	21	(18,609,245.93)	(120,894,401.01)
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)		3,361,442,896.15	1,055,841,124.10
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		3,361,442,896.15	1,055,841,124.10
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-
Бусад олз (гарз)		-	-
Орлогын нийт дүн		3,361,442,896.15	1,055,841,124.10
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		-	-

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний өдөр	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(9,297,622,828.42)	(4,059,366,034.60)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-	-
Залруулсан үлдэгдэл	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(9,297,622,828.42)	(4,059,366,034.60)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга)					-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,055,841,124.10	1,055,841,124.10
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
2025 оны 12-р сарын 31-ний өдөр	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(8,241,781,704.32)	(3,003,524,910.50)

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

		/төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2024	12/31/2025
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	31,661,700,823.58	10,478,339,774.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	12,459,425,880.00	10,334,945,736.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Бусад мөнгөн орлого	19,202,274,943.58	143,394,038.00
Мөнгөн зарлагын дүн (-)	31,398,021,118.14	9,140,349,697.72
Ажиллагчдад төлсөн	130,361,032.35	183,339,832.87
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	18,549,573.94	28,135,613.78
Ашиглалтын зардалд төлсөн	3,814,287,040.03	4,192,901,957.24
Түлш шатахуун,сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	3,268,774.00
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	108,303,574.62	767,025,775.30
Хүүний төлбөрт төлсөн	2,037,260,273.97	2,429,813,698.78
Татварын байгууллагад төлсөн	839,544,209.23	696,745,232.51
Даатгалын төлбөрт төлсөн	186,000,000.00	186,000,000.00
Бусад мөнгөн зарлага	24,263,715,414.00	653,118,813.24
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	263,679,705.44	1,337,990,076.28
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	22,870,339.20
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	22,870,339.20
Мөнгөн зарлагын дүн (-)	219,123,112.76	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	219,123,112.76	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(219,123,112.76)	(22,870,339.20)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	10,002,880,143.35	3,150,093.04
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,000,000,000.00	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,880,143.35	3,150,093.04
Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000,000.00	1,200,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	10,000,000,000.00	1,200,000,000.00
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,880,143.35	(1,196,849,906.96)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	47,436,736.03	164,010,508.52
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	<i>234,811.20</i>	<i>47,671,547.23</i>
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	<i>47,671,547.23</i>	<i>211,682,055.75</i>

Хурлын дарга Я.Наваан: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 13-ны өдрийн 26/03 дугаартай тогтоолоор компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хангалттай гэж дүгнэсэн байна. (гээд ТУЗ-ийн дүгнэлтийг хавсралтын хамт дэлгэц дээр харуулж танилцуулав)

За ингээд хурлаар хэлэлцэх 1-р асуудалтай холбоотой танилцуулгыг хийж дууслаа. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулъя.

Компани тайлант жилийн болон өмнөх онуудад бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй, “Хаан банк” ХК, “Голомт банк” ХК-уудад төлөх өндөр дүнтэй зээлийн үлдэгдэлтэй байгаа зэргээс үүдэн Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан “ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх”, “ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх” шаардлагуудыг хангаж чадахгүй байх тул 2025 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. (гээд ТУЗ-ийн тогтоолыг дэлгэц дээр харуулж танилцуулав)

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН ХОЁРДУГААР АСУУДАЛ:

Ингээд хурлаар хэлэлцэх 2 дахь асуудал буюу 2026 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг батлах асуудалдаа оръё. Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч та бүхнийг энэ танилцуулж буй зардлыг төсвийг баталж өгөөчээ гэж хүсье гээд дараах төсвийг танилцуулав.

№	Төрөл	Төсөв /Төгрөг/
1	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал	31,500,000
2	ТУЗ-ийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах төсөв	6,600,000
Нийт төсөв		38,100,000

Зардлын нийт төсвийг 38,100,000 төгрөгөөр төлөвлөж байна. Өнгөрсөн жил бол 42.8 сая төгрөгөөр төлөвлөж байсан. Энэ нь бол 2026 оны 4-р сараас эхлээд ирэх оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх 12 сарын хугацааны зардлын төсөв байгаа. Үүнд ТУЗ-ийн 9 гишүүний цалин урамшуулалд 31,500,000 төгрөг, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахад бас тодорхой хэмжээний зардал гардаг. Үүнд 6,600,000 төгрөг төлөвлөсөн байна. Энэ зардлыг хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын эцэст саналын хуудсаар санал өгөхдөө шийдвэрлэж өгөх ёстой байгаа.

Хурлын дарга Я.Наваан: Ингээд хурлын дарга миний санал хураах асуудалтай холбоотой танилцуулга дууслаа. Одоо хувьцаа эзэмшигчдээс үг хэлэх, санал гаргах, асуулт асуух үе шат эхэлж байна. Хувьцаа эзэмшигчид нэг нэгээрээ дэс дараалаад үгээ хэлээд асуултаа асуугаад явъя. Та бүхний хэлэх үг, асуултыг нэг мөр сонссоны дараа тус бүрийн асуултад хариулт өгөөд явъя.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: ТУЗ-ийн гишүүдийг танилцуулж өгөөч. Ямар зарчмаар яаж сонгогдсон бэ? Мөн ТУЗ-ийн төсвийн зардлын талаар танилцуулаач ТУЗ жилд хэдэн удаа хуралдсан бэ? Мөн борлуулалт буурсан харагдаж байна. Энэний учрыг тайлбарлаж өгөөч. Мөн Санхүүгийн тайланд урьдчилж төлсөн зардал гээд 184 сая төгрөг байна. Энэ ямар учиртай зардал вэ? Ногдол ашгийн өглөг гээд ноднин бас 15 сая төгрөг байсан энэ жил бас хэвээрээ л байна. Энэ хэзээний ногдол ашгийн өглөг вэ?

Хувьцаа эзэмшигч: Компани намайг хувьцаа эзэмшигч болсноос хойш нэг ч удаа ногдол ашиг өгч байгаагүй. Миний санал бол ТУЗ-ийн даргын албан тушаалд энэ хувьцаа эзэмшигчдээсээ оруулмаар байна. Жижиг хувьцаа эзэмшигчид нийт хувьцааны 30 гаруй

хувийг эзэлж байгаа. Энэ дотроосоо ТУЗ-ийн даргыг томилмоор байна. Одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүд ажлаа хийж чадахгүй байна. Та нар чадахгүй бол энэ их дэлгүүрээ улсад нь буцааж өгөх хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч Д.Соёлмаа: Би их дэлгүүрт хувьцаагаа өгснөөс хойш нэг ч удаа ногдол ашиг авч үзээгүй. Би өмнө нь үг хэлсэн бусад хувьцаа эзэмшигчидтэй мөн адил саналтай байна. Сая танилцуулгад түрээсийн төлбөрийг 7%-иар нэмэгдүүлсэн гэж байна. Тэгэхэд өнөөдөр улс эх орны санхүүгийн байдал, юмны үнэ хэдий хэмжээгээр өссөн билээ. Гэтэл яагаад түрээсийн төлбөрөө 7 хон хувиар нэмсэн бэ энийг хангалтгүй гэж харж байна. Ашиглалтын зардал өссөн гэж байна. Энэ яагаад өссөн бэ? Мөн барилгын засварын зардал нэмэгдсэн гэж байна. Түрүүн танилцуулснаар их дэлгүүрийн барилга даатгалтай байсан гэж байна. Барилгын засварын зардалд хэдэн төгрөг зарцуулагдсан, хэд нь даатгалаас гарсан бэ? Ямар даатгалын компанид даатгуулсан бэ? Тэрнээс гадна Санхүүгийн зохицуулах хорооноос компанид шалгалт хийсэн ш дээ. Тэр үед Санхүүгийн зохицуулах хорооны шаардлага юу байсан, тэрний мөрөөр ямар арга хэмжээ авагдсан бэ? Улсын их дэлгүүр ХК-ийн үйл ажиллагаатай холбогдолтой бичиг баримттай танилцах хүсэлттэй байна. Гэхдээ яг одоо гээгүй ерөнхийдөө танилцмаар байна. Миний хувьд компанийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

Хувьцаа эзэмшигч А.Гандиймаа: Энэ хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүдийг уг нь байлгавал зүгээр байна. Өнгөрсөн жилийн хурал дээр энэ 4 залуу ингээд л сууж байсан. Сая ярьсан зүйлүүдээ л ярьж байсан. Ашигтай ажилласан мөртлөө ногдол ашиг хуваарилахгүй гээд бас л ийм юм ярьж байсан. 30 жил болж байна шд. Би их дэлгүүрийн хувьцааг байлгаад байдаг шалтгаан нь бол тэр барилгад оруулсан асуудал. Тэнд түрээсийн үйл ажиллагаа явагддаг. Тэр дэлгүүрт хэчнээн түрээслэгч байдаг, тэнд ямар хүмүүс ажилладаг вэ? Мэдээж цэвэрлэгч, зохион байгуулагч гээд үйлчилгээний хүмүүс ажиллаж байгаа байх. Би өөрөө ч объект түрээслүүлээд түрээсийн орлого авдаг хүн. Тэрний ашиг зардал 2-ыг харьцуулаад үзэхэд дажгүй ашигтай ажилладаг. Ер нь зүгээр хар ухаанаар бодоход түрээс авч байгаа газар хэзээ ч ашиггүй ажилладаггүй. Тэгэхэд ингээд 30 жил ногдол ашиг өгдөггүй. Би энэ жил өгөх байх гэж горьдож ирсэн. Ноднин би хурал дээр бас л энэ асуудлыг ярьсан. Үнэхээр өгдөггүй юм байна. Одоо бид тэгвэл энэ хувьцаагаа яах вэ? Яаж борлуулж зарах вэ? Хөрөнгийн бирж дээр хувьцаа борлуулж зарж өгдөг өчнөөн компаниуд байдаг юм байна лээ. Маш сайн борлуулдаг өндөр үнээр. Тэгэхэд Номин ерөөсөө байхгүй. Хараат бус гишүүдээс хурал дээр уг нь асуух юм байна. Бидний төлөө яаж ажиллаж байгаа вэ, жижиг хувьцаа эзэмшигчдийн өмнөөс дугараад явахгүй юм уу яагаад хурал дээр ирдэггүй юм бэ. Өмнө хурал дээр бас л энийг шаардаж байсан. За миний асуух юм бол Улсын их дэлгүүр компанид ажилладаг хэдэн хүн байдаг вэ? Яг ямар ажилтнууд байдаг вэ? Тайлангаас харахад НД-ын шимтгэлийн жилийн төлөлт, хүн амын орлогын албан татварын жилийн төлөлтийг харахаар олон хүн байдаг юм шиг харагдаж байна. 19 сая, 21 сая төгрөг ингээд өмнөөс нь төлөөд явдаг юм байна шд. Хоёрт асуулт их дэлгүүр хэдэн лангуу түрээслүүлдэг вэ? 1 давхарт гэхэд л Номингийн хүнсний дэлгүүр байдаг. Тэр түрээс төлдөг юм байгаа биз дээ.

Хурлын дарга Я.Наваан: Компани бол дэлгүүрийнхээ барилгыг бүхэлд нь Номин реалтор ХХК-д түрээслүүлдэг. Номин реалтор ХХК нь цаашаа жижиглээд түрээслүүлээд явдаг.

Хувьцаа эзэмшигч А.Гандиймаа: Энэ түрээсийн үйл ажиллагааныхаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл бидэнд өгөх ёстой.

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Компани орон тооны 4 ажилтан байдаг. Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, 2 нягтлан бодогч ажилладаг. Тайланд

тусгагдсан НДШ болон татварын зардал нь тухайн 4 хүний бүтэн жилийн цалингаас бодогдож байгаа шимтгэл, татвар юм.

Хувьцаа эзэмшигч А.Гандиймаа: Бас нэг асуудал байна. Компанийн эздийн өмч нь хасахтай гарсан гээд. Түрүү жил нэмэх байсан юм уу? Мөн энэ дээр халаасны хувьцаа гээд 175 сая төгрөг байна энэ ямар учиртай вэ? Халаасны хувьцаа гэж юуг хэлээд байна вэ? Мөн тайлан дээр ногдол ашгийн өглөг гэж юм байгаа. Энэ одоо юу вэ? Ногдол ашиг хэн ч аваагүй байтал өглөг гээд бүртгэчихсэн байна.

Хувьцаа эзэмшигч Д.Жамуух: Би жижиг хувьцаа эзэмшигчдийн нэг байна. 30 жил боллоо. Ямар ч ногдол ашиг алга. Одоо энэ бага хувьцаа эзэмшигчдээ цаашид яая гэж бодож байна вэ? Ингээд байлгаад байх юм уу? Их дэлгүүрийн үйл ажиллагааг бид маш сайн ойлгож байна. Бидний юм байсан бол хэнд түрээслүүлээд яаж ашгаа олоод явах байсан бэ гэдгийг сайн мэдэж байна. Тэгээд та нар ямар ч ашиггүй гаргаад, за яахав том хувьцаа эзэмшигч нар 60 хувийг эзэмшдэг юм байж. Гэхдээ энэ үлдсэн 30 хэдэн хувийг эзэмшиж байгаа хүмүүсийг бас жаахан харж үзмээр байна ш дээ. 30 жил юу ч өгсөнгүй шд та нар. Тэгээд одоо энэ зөвхөн хурал зохион байгуулах зардал 6 сая төгрөг ч гэх шиг. Наад тоонуудыг чинь хараад хүлээн зөвшөөрөхөд хэцүү байна. Их дэлгүүрийг ашигтай ажиллуулж чадахгүй байна гэж байхгүй шд та нар. Хамгийн ашигтай ажиллуулж байгаа шд. Наад тайлан баланс чинь худлаа гараад байна. Хэчнээн хүн ажиллаж байгаа, хэдэн төгрөгийн ашиг авч байгаа нь ерөөсөө тодорхой бус байна. Номингийн талд л ажиллаад байна. Асуухаар Номин бол зүгээр хувьцаа эзэмшигч л гэж тайлбарладаг. Түрүүн асуусан шд Номин хэдэн төгрөгөөр түрээсэлдэг вэ гэхэд байхгүй л байна шд. Энийг та зүгээр дотроо зохицуулж байгаа. Одоо тэгээд энэ жижиг хувьцаа эзэмшигчдийг яах юм бэ? Энэ талаар л яриад өг. Цаашид яамаар байна. Ашигтай ажиллуулах уу? Ногдол ашиг өгөх юм уу өгөхгүй юм уу? Ингээд л дуусах юм уу яах юм бэ?

Хувьцаа эзэмшигч Д.Алтанцэцэг: 30 жилийн хугацаанд та нар ашиггүй ажиллана гэж хэзээ ч байхгүй. Та нарын амжиргааны түвшин дээшилсэн байна. Түрээслэгч нь их болсон байна. Өнөөх хувьцаа эзэмшиж байсан эмээ өвөө нар байхгүй болсон байна. Ноднин уржнан хуралд сууж байсан эмээ өвөө нар одоо байхгүй байна шд. Энэ мэтчилэнгээр 30 жил хууртсан байна. Номинд ороод би жишээ нь ердийн дэлгүүрээс хамаагүй өндөр үнээр юм авдаг шд. Эднийх хөгжиж байна, сайхан болж байна гэж хардаг болохоос эднийх яанаа гэж өрөвддөггүй. Тэгэхээр та нараас нэг зүйл хүсье. 1994 онд ногдол ашгийн тухай тогтоол гарсан байна. Тэр аль 20-р зууны тогтоол дээр тухайн үед компаниудыг үүсгэж байгуулж байх үед харж үзье гээд хувьцаанд коэффициент өгсөн байнаа даа. Тэдэн хувийн тийм коэффициентээр ногдол ашиг өгнө гээд. Одоо 21-р зуун гараад 26 жил болоод байхад 20-р зууны 1994 оны коэффициент өөрчлөгдөхгүй. Ингэсэн чинь тэгсэн гээд шалтаг тоочоод байх юм. Бид яагаад тэгвэл ингээд мөлжүүлээд байгаа юм бэ? Та нэр ийм гоё юмны эзэн байж дандаа байхгүй, болохгүй, дандаа өр ярьсан байдалтай байна. Нэг айлын өрх толгойлсон эмэгтэй би эдийн засгаа өөрөө бариад, өрөө зохицуулаад, дараад, тооцоогоо шахаад ингээд л явдаг шд. Би одоо тэтгэвэрт гарсан эдийн засагч хүн. Яаж ч бодсон, ямар ч зардлыг яаж ч нөхөөд шахсан ч та нар ашигтай ажиллаж байгаа. Тэгэхээр 21-р зууны коэффициентоо өөрчлөхийн тулд Санхүүгийн зохицуулах хороотойгоо ярьж байгаад ядаж энэ үлдэж байгаа хэдэн буурлууддаа ашгийг нь, мөнгийг нь өгөөч. 30 жил юу ч өгөөгүй тэгээд энэ их дэлгүүр чинь байх шаардлагатай юм уу? Нэг муу өрх толгойлсон ядарсан эмэгтэйдээс долоо дор харагдаад байна.

Хувьцаа эзэмшигч: Би ноднин санал, шүүмж тавьсан. Энэ талаар бас хэлсэн. Тэр санал, шүүмжийн талаар ямар арга хэмжээ авсан талаар тайлбарлаж өгөх хүн байна уу? 2-рт 1995 онд улс орны зүгээс ард түмнээ өөд нь татахын тулд 100 гаруй ширхэг хувьцаа өгсөн. Энэ хувьцааг нь ард түмэн өөрсдөө сонгоод өгөх газраа өгөөд явсан. Гэтэл өнөөдөр

30 жил болж байхад тэр хувьцааныхаа ашгийг хүртэхгүй, ганц ч төгрөг авч чадахгүй явж байна. Энэ 2024, 2025 оны тайланг чинь харьцуулаад харахад 2024 мөнгөн орлогын дүнгээр 31 тэрбум төгрөг, 2025 оных болохоор 10 тэрбум төгрөг байна. Энэ 2024 оны тайлангийн үлдэгдэл чинь өссөн дүнгээр явдаг юм уу тухайн жилийн дүн юм уу? Эндээс харахад бол та нар бас л ашиггүй юм хийсэн харагдаж байна. Магадгүй би энэ тайланг хараад ойлгохгүй ч байж болно. Ингэж жил жилээр их зөрүүтэй гарсан байна. Урд талын тайлан өссөн дүнгээр гарсан үгүйг би мэдэхгүй байна. Ноднин та нар юу гэж ярьсан бэ гэхээр их дэлгүүр шатсан, тэрийг сэргээн засахын тулд өчнөөн зардал гаргаад компани мөнгө муутай байна. Ийм асуудал гарсан учраас энэ жил та бүхэнд ногдол ашиг өгөхгүй гэж ярьж байсан. Тэр галын хохирлыг сэргээн босгохын тулд та нар даатгалаас тодорхой хэмжээнд мөнгө авсан байгаа. Гэтэл эндээс авсан мэтээр бидэнд ойлгуулж, галаас болж ашиггүй ажилласан. Тийм учраас ногдол ашиг олгохгүй гээд яриад сууж байсан. Та нар өнөөдрийн байдлаар 1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарч байна. Тэгэхээр энэ тухайн жилд гарч байгаа энэ цэвэр ашгаас хуваарилалт хийх ёстой. Энэ ашгаас бид эзэмшиж байгаа хувьцааныхаа тоогоор ногдол ашиг авах ёстой. Ямар ч аж ахуйн нэгжийн тайланд цэвэр ашигтай гарсан тохиолдолд ногдол ашгийн хуваарилалт хийдэг. Гэтэл өнөөдөр та нар манай байгууллага ерөөсөө ашиггүй, маш их өртэй гээд яриад сууж байна. Тэр цэвэр ашгийг заавал бүгдийг нь тараа гээгүй. Тодорхой хувийг нь хуваарилах ёстой. Та нарын наад яриад байгаа өр төлбөр гэдэг чинь та нарын асуудал. Ашгаасаа хуваарилалт хийгээд үлдсэнээр нь зохих ёсны өр төлбөрөө төлөх ёстой. Сая хүртэл ярьж байна. Дулааны үнэ өссөн гэнэ үү.

Хувьцаа эзэмшигч А.Гандиймаа: Дулааны үнэ өснө гэж төлөвлөсөн чинь өсөөгүй гэж ярьсан.

Хувьцаа эзэмшигч: Гүй тэгээд дулааны зөрдөл өснө гээд төлөвлөлт хийсэн чинь тэр зардал гараагүй л юм байна шд. Тэр нь тэгээд яаж нөлөөлж байдаг юм. Би тэрийг сайн мэдэхгүй байна. 100 сая төгрөгийн дулаан цахилгааны зардал гарна гээд төлөвлөсөн байхад 50 саяын зардал гарсан бол 50 сая нь төлөөгүй учраас компанид ашигтай гарахаар байтал төлөвлөгдөөгүй учир бид энэнээс болж өр төлбөртэй гарлаа гэж яриад байдаг. Би энийг буруу ойлгож байж магадгүй. Тухайн үед ашигтай ажиллахад тэр байгууллага өртэй байна уу, мэдээж өртэй бол ашгаас төлөх байх л даа. Гэхдээ ашиг хуваарилахгүйгээр цэвэр ашгаас өөрсдийнхөө өрийг төлөөд явж байдаг. Энэ чинь өөрөө тухайн байгууллагын дотоод ажил. Ингээд ашиг гарахаар нь өрөө төлөөд явж байдаг. Хууль дүрэмд тэгж заасан юм байхгүй байх. Байгууллага ямар ашигтай гарна тэрүүгээрээ өрөө төлж бай харин ногдол ашиг битгийн өг гэсэн тийм зүйл байхгүй шүү. 30 жил бид цагаа алдсан хүмүүс. Та нар нэгэнт юм өгөхгүй юм бол яах гэж ингэж хурал хийгээд энэ хүмүүсийг цуглуулаад байдаг юм. Ноднингийн та нарын тогтоол шийдвэрийг бид ерөөсөө баталж өгөөгүй. Цугласан хүмүүс бүгд үгүй гэж хэлээд гарсан. Тэгээд өнөөдөр тэрний хариу юу байгаа вэ, бид тэрнээс хойш ийм ийм арга хэмжээ авсан тэгсэн ингэсэн танилцуулахгүй байна. Тэгээд дахиад л ингээс цуглуулаад авчирчихсан байна. Бид ажлаа алдсан хүмүүс биш. Ногдол ашиг өгөхгүй юм бол та нар энэ хүмүүсийг дахиж бүү цуглуулж хурал хий.

Хувьцаа эзэмшигч А.Гандиймаа: Энэ хүний ногдол ашгийн хуваарилалтын талаар яриад байгаа нь зөв ш дээ. Тайлан баланс гарлаа, ашигтай ажиллаа, тэр ашгийн хуваарилалт заавал хийгдэх ёстой. Тухайн үед жилийн дотор та нар ашгаасаа зээлээ ч төлж байгаа хүүгээ ч төлж байгаа. Тийм болохоор энэ ашигтай ажилласан дүнгээс ашгийн хуваарилалт хийх болохоос та нар бусад өрөндөө өгөх ёсгүй. Ноднин яг ийм асуудал яриад би анх удаа оролцсон болохоор илүү дутуу юм ярилгүй дуугүй гарсан. 2 дахь удаагаа өөр болох болов уу гэж орж ирсэн яг адилхан юм ярьж байна. Ийм байдалтай байвал бид ингээд суухгүй. Энэ олон уулзаж, цуглаж нэгдэж байгаад энэ асуудлыг шийдвэрлэх болно. Ашгаа авдаг болно. Номингийн энэ хэдэн хүмүүст дарлуулаад 30 жил ингэж явж болохгүй.

Энэ бидний юм болохоор бид энэн дээр тэмцэнэ. Энэ удаад анхааруулъя. Цаашдаа та нар ийм байдал гаргавал бид тэмцэнэ шүү.

Хувьцаа эзэмшигч: Ер нь бол би хүмүүсээс сонссон. Танайхыг шүүхэд өгөөд нэмэргүй байдаг гэж. Мөн энэ байдлыг жил болгон яриад нэмэргүй, засагддаггүй гэж ярьж байна. Энэ жилийн цэвэр ашиг 1 тэрбум төгрөгөө энэ хүмүүст хуваарилж өг. ТУЗ-ийн дарга та энэ асуудлыг гаргаж тавиад энэ ногдол ашгийн хуваарилалтыг хийлгүүл.

Хувьцаа эзэмшигч: Бид нар дараа жилээс нэмэгдэнэ гээд аваагүй л дээ. Одоо тэрийг жаахан нэмчихвэл та нарын өсөж хөгжих нь танай асуудал ш дээ. Хувьцаа эзэмшигчдээ харж үзэхгүйгээр урагшаа хэд алхах гээд байгаа юм бэ.

Хувьцаа эзэмшигч Д.Буянжаргал: Компани олон жилийн турш бидэнд ногдол ашиг өгөөгүй. Одоо энд цугласан хүмүүсээс гадна цахимаар хэлэн хүн хуралд оролцож байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Цахимаар 4 хүн л оролцож байна.

Хувьцаа эзэмшигч Д.Буянжаргал: Түрүүн 58 хүн гэж хэлсэн шд тэр ямар учиртай вэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Урьдчилан бичгээр санал өгсөн хүмүүс нь 58 хүн байгаа юм. Урьдчилан саналын хуудсаар санал өгсөн хүмүүс хурлын ирцэд тооцогдоод явж байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Ганцэцэг: Миний хувьд 3 жилдээ хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байна. Өмнөх хүмүүстэй санал давхардуулаад яахав. Нэг шинэ зүйл хэлэхэд бид уг нь Улсын их дэлгүүрийн хувьцаа эзэмшигч нар ш дээ. Тэгэхээр Улсын их дэлгүүртээ хурлаа хийж баймаар байна. Тэгвэл ядаж бид хувьцаагаа оруулсан дэлгүүрээ ядаж жилд 1 удаа хараад, үйл ажиллагаа нь яаж явж байгаагаар танилцаад явна. 2-рт 2025 оны тайлангаар өмнөх жилүүдийн тайлангаа бодоход 1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байгаа нь талархуштай байна. Гэхдээ энэ ашгаа хүмүүстээ хуваарилж өгмөөр байна. Хүмүүс чинь ашиг авна гээд л горидоод хуралдаа ирж байгаа ш дээ. 30 жил хувьцаагаа ашиглуулаад Номинг өсөж дэвжихэд нь нэлээдгүй хувь нэмэр оруулсан л байгаа. Өмнө нь 20-оод жилийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хуралд ирж байхад хурлын дарга нь бид эхлээд үйл ажиллагаагаа сайжруулаад томруулаад ашигтай болсны дараа ногдол ашгаа өгч эхэлнэ гэж хэлж байсан. Одоо хүмүүсийн нүдэнд угаасаа ил харагдаж байна шд Номин яаж хөгжиж байгаа нь. Номин тухайн үед зүгээр л их дэлгүүрийн лангуу түрээслэгч байсан. Гэтэл одоо маш том 60 гаруй хувийг эзэмшигч болчихсон байна. Энэ 60 гаруй хувийн хувьцааг яаж олж авсныг нь бид бүгд мэдэж байгаа. Ямар ч мэдлэг, мэдээлэлгүй хүмүүсийн хувьцааг хямдаар худалдаж аваад 60 хувь эзэмшдэг болчихсон л байгаа байх. Гэхдээ тэр яахав тухайн бизнес эрхлэгч нарын л асуудал байх л даа. Ерөөсөө мэдлэггүй хүмүүс нь ингээд л бахь байдгаараа байж байдаг. 30 жил хувьцаагаа ашиглуулж байгаа хүмүүс үнэхээр их дэлгүүр маань томроно шүү, ашигтай байна шүү, бидэнд өр өгөөжөө өгнө шүү гэсэн хүсэлтэй л хүмүүс байгаа. Тэгээд хуралдаа ингээд оролцож байна. Яахуу ийхүү гээд мэдэхээсээ мэдэхгүй нь ингээд сууж байна. Тэгэхээр энэ мэдээллийг маш сайн хангаж өгч баймаар байна. Тэгээд бид чинь их дэлгүүр яагаад ингээд ашигтай, ашиггүй байна гээд ажилд нь бас оролцмоор байна шд. Төлөөлөн удирдах зөвлөлд ч гэсэн сонгогдож ажилламаар байна. Тэгж байж бодитой мэдээлэл авмаар байна. Жил бүр л ярьдаг юмаа яриад ингээд байгаад байж болохгүй. Жаахан өөрчилмөөр байна.

Хувьцаа эзэмшигч Шигшээ: Миний сонссоноор компани эхэлж хувьчлагдах үед Эрдэнэт үйлдвэрт хувьцаагаа өгнө гээд санал оруулсан байсан хүмүүсийг Улсын их дэлгүүрлүү оруулсан гэдэг асуудал яригдаж байсан. Энэ асуудлыг яаж шийдсэн юм бол тэр талаар мэдээлэл өгөөч.

Хурлын дарга Я.Наваан: Тэр талаар бид лавлахгүй бол одоо тодорхой мэдээлэлгүй байна. За цахимаар оролцож байгаа хүмүүсээс санал хэлэх, асуулт асуух хүн байна уу?

Хувьцаа эзэмшигч Д.Гантөгс: Хүмүүсийн ярьж байгаа үнэн байна. Ногдол ашгаа өгөхгүй байгаа нь хувьцаа эзэмшигчдээ доромжилж байгаа үйлдэл бишүү. За энэ хурал бол яахав ингэсгээд тайлангаа танилцуулаад явдаг. Ядаж бидний ойрын төлөвлөгөө ийм байна, бид цаашид ингэж ажиллана, ийм үр дүнд хүрнэ гэх мэтчилэн асуудлаа танилцуулдаггүй юм уу. Зөвхөн тайлан тавиад орхичихдог. Жил бүр хүмүүсийг ингэж цуглуулчихаад нөгөө л ярьдаг юмаа яриад байдаг. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс одоо явдаг газраар явна, шүүхдэнэ. Та нарын энэ олон жил ингэж луйвардаж ирсэн арга барилыг чинь би сайн мэднэ. Дараагийн хурал дээр та нар хэтийн төлөвөө яримаар байна. Дараагийн 5 жилд ингэж ажиллана гэх мэтээр.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Онлайнаар орж байгаа хүмүүсээс өөр санал хэлэх, асуулт асуух хүн байна уу? (хэсэг хүлээхэд өөр санал хүн байгаагүй)

Хувьцаа эзэмшигч Г.Баасан: Би өөрөө Улсын их дэлгүүрт худалдагч хийж ажиллаж байсан хүн байгаа юм. Тэрнээс хойш 38 жил болжээ. Бидэнд ашиг өгөөгүй байна. Их дэлгүүр ямар их ашигтай ажилладагыг мэднэ. Анх өөрөө агуулах складтай, лангуу байсныг одоо бүх складыг буулгаад одоо дан түрээслэгч болчихоод байгаа. Тэгээд тэр хүмүүс өөрсдөө яагаад ингээд амжилтад хүрчихээд биднийг хүүхэд хуурч байгаа юм шиг тийм ч ашиггүй гэсэн яриад сууж байдаг. Би нэг хэсэг Санхүүгийн зохицуулах хороонд өргөдөл өгөөд хүмүүстэй нийлж тэмцээд явсан. Тэгээд Санхүүгийн зохицуулах хорооноос аудитын шалгалт оруулаад их дэлгүүр яаж ч бодсон ашигтай ажиллах компани мөн гээд шинээр ТУЗ томилоод, ажлыг нь сайжруулаад явъя, ногдол ашиг өгөх боломжтой гээд шийдвэр гарч байсан тухайн үед. Тэгээд та хэдийг томилсон байх л даа. Сайхан шинэ залуучууд л байна. Тэгээд та нар чинь бид нарын төлөө ажиллаад байгаа хүмүүс биз дээ. Одоо үл хөдлөх хөрөнгө ямар үнэтэй болсон билээ, энэ түрээсийн байрнууд ямар үнэтэй байгаа билээ. Тэгэхэд яагаад бидэнд хэдэн төгрөг өгөөд ажиллаж чадахгүй байгаа юм бэ? Дээр үеэсээ л гадаад дотоодын жуулчид их дэлгүүрээр их үйлчлүүлдэг байсан. Одоо бол бүр илүү хөл хөдөлгөөнтэй, хүн бүхэн орох дуртай, сайхан ч газар. Тэгэхэд тийм гоё дэлгүүрийг ингээд ашиггүй ажиллуулаад байдаг юм бэ? Жижиг хувьцаа эзэмшигчид нь энэ хэдэн цөөхөн хүн байна ш дээ. Бид нар амьдралаа дээшлүүлэх гээд л танай хувьцааг чинь авсан байгаа ш дээ. Яагаад ингээд сэтгэл гаргахгүй байгаа юм бэ? Номин өөрөө ямар их баян, том газар билээ. Компаниас цэвэр ашиг гэж гарч байгаа л бол тэрийг зохих хэмжээний хувьд нь тааруулаад ногдол ашгаар өгөх ёстой. Татварын дараах цэвэр ашиг гээд гараад ирсэн байхад яагаад ногдол ашиг өгөхгүй байгаа юм бэ? Хэн ч гэсэн шалтаг, шалтгаан хэлээд энэ тоонуудыг засаад янзлаад тавьчихаж болно л доо. Яг бодитоор үнэн зөв явмаар байна.

Хувьцаа эзэмшигч (Нэрээ хэлээгүй): Жижиг хувьцаа эзэмшигч нар зохих хэмжээгээр цөөхөн л хүмүүс байдаг юм байна ш дээ. Би сүүлд Хас банкны хувьцаа худалдаж авсан. Тэндээс аягүй их ногдол ашиг авсан. Нэгж хувьцааны үнэ яагаад ингээд өсөхгүй хэвэндээ яваад байгаа юм бэ? Жил бүр шинэчлэгдэх ёстой биз дээ. Инфляци өсөөд байхад хувьцааны үнэ өсөхгүй байна.

Хувьцаа эзэмшигч (Нэрээ хэлээгүй): Улсын их дэлгүүр чинь бүх давхруудаа Номинд түрээслүүлдэг ш дээ. Гэтэл ашиг нь хаана байна? Номингийн компаниудтай хийсэн гэрээний талаар ярьмаар байна. Хэзээ ямар гэрээнүүд хийсэн бэ гэдгийг.

(Хувьцаа эзэмшигчид хэн, ямар асуулт асууж байгаа нь тодорхойгүй бүгд зэрэгцэж ярьж, шаардлага тавьж эхэлсэн тул хурлын тэмдэглэлд бичигдэх боломжгүй болсон)

Хурлын дарга Я.Наваан: За хувьцаа эзэмшигчдээ хурлаа дэгийн дагуу явуулъя. Та бүхэн асуултандаа хариултаа аваад, тайлбараа сонсоод явна уу. Саналын хуудсаар та бүхэн хэлэлцэж байгаа асуудалд саналаа өгөөд явна. Та бүхэн зөвшөөрч болно, татгалзаж болно. Тэгэхээр эхлээд би та бүхий асуултад хариулт өгье. Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгодог бөгөөд хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцааны саналын эрхийн дийлэнх олонхоор сонгоод явдаг байгаа. Одоогийн ТУЗ-ийн гишүүдийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгосон. Зарим нэг гишүүнийг өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нөхөн сонгосон. Тухайн хурал дээр нэр дэвшиж байгаа гишүүдийн талаар маш дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулж байсан. 9 гишүүний 6 нь ердийн гишүүд 3 нь хараат бус гишүүд байгаа. Энэ нь хуулиар тавигдсан хараат бус гишүүний шаардлагыг хангаад, Санхүүгийн зохицуулах хороо хяналтаа тавиад, зөвшөөрөгдөөд ингээд явж байгаа. За эдгээр ТУЗ-ийн гишүүдээ төлөөлөөд хэлэхэд бид жилээс жилд та бүхнийхээ хэлж байгаа зөвлөмж, саналуудыг хэрэгжүүлэх гээд ажиллаж байгаа. Хамгийн наад захын жишээ бол бид сүүлийн хэдэн жил хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг танхимаар биечлэн зохион байгуулж байна. Ковидын үед бол ингэж хуралдах боломж байхгүй байсан. Жил бүр ингээд та бүхэнтэй уулзаад нүүр нүүрээ хараад, ямар хүмүүс та бүхнийг төлөөлөөд, яаж ажиллаад байгаа вэ гэдэг мэдээллийг хэр хэмжээндээ өгөөд байгаагийн үр дүнд миний анзаарч байгаагаар сүүлийн 3 жилийн хурлаас бараг 3 дахин их хувьцаа эзэмшигчид цуглаад, онлайнгаар давхар ороод явж байна. Та бүхний өгсөн чиглэлийн дагуу компанийг аль болох нээлттэй ажиллуулах гээд хичээж байгаагийн үр дүн гэж харж байна. Ингээд эдгээр ТУЗ-ийн гишүүд та бүхний төлөөлөөд хараат бус бол хараат бус шийдвэрээ гаргаад, хуулийн хүрээнд шийдвэрээ гаргаад явж байгаа. Та бүхний асуултууд дотор нэлээдгүй давхцаж байгаа асуултууд бол түрээсийн үйл ажиллагаатай холбоотой асуултууд байна. Би энийг тайлбарлаж өгье. Улсын их дэлгүүр ХК нь Номин реалтор ХХК-тай түрээсийн гэрээтэй бөгөөд Номин реалтор ХХК нь Улсын их дэлгүүрийн барилгыг бүхэлд нь түрээсэлдэг. Ингэж бүхэлд нь түрээслүүлэхээр ямар давуу талууд бий болдог вэ гэхээр бид урт хугацааны түрээсийн гэрээгээр түрээсийн үнийг тогтвортой өсгөх хуваарь тохирчихож байгаа юм. Гэтэл одоо манай Улаанбаатар хот дахь үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаатай холбоотой судалгаануудыг нарийвчлаад үзвэл их сонин дүр зургууд харагддаг. Өнөөдрийн байдлаар түрээсийн дүүргэлт 70% хүрэхгүй байна гэсэн судалгааг мэргэжлийн үл хөдлөх хөрөнгийн компаниуд хийсэн байдаг. Өөрөөр хэлбэл тухайн барилга зарим үедээ нэг их сайхан харагдаад, зарим үедээ 30 гаруй хувь нь хоосон талбай байж байна гэсэн үг. Харин хувьцаа эзэмшигчид та бүхэн ямар сонголтыг бидэнд чиглүүлж өгсөн бэ гэхээр Номин реалтор ХХК-д бид 100%-ийн дүүргэлттэйгээр талбай хоосон байна уу ямар байн уу хамаа байхгүйгээр надад м.кв тутмаас түрээсийн төлбөрийг тогтвортой төлөөд яв гэдэг ийм график хуваарь тохироод гэрээ байгуулах эрхийг өгсөн. Тэгэхээр санхүүгийн тайлангаас харахад манай орлого урт хугацаандаа тогтвортой өсөж байгаа. Бид 1 м.кв талбайгаас ч гэсэн тэнд түрээслэгч байсан ч байгаагүй ч төлбөрийг нь аваад явж байгаа. Ингэхээр хамгийн найдвартай хувилбар болж байгаа юм. Харин тэр санхүүгийн тоон үзүүлэлт ямар үед өсөөд ямар үед буурсан бэ гэхээр түрээсийн бус орлого орж ирсэн өсөөд, бусад үед түрээсийн орлого тогтвортой өсөж явж байгаа. Үүнийг манай гүйцэтгэх захирал Эрдэнэбаатар дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө. За ингээд тогтвортой орлого аваад яваад байгаа нь манай Улсын их дэлгүүр ХК-ийн үйл ажиллагаа найдвартай, мөнгөө хугацаанд нь авдаг, жилээс жилд өргөжин тэлэх боломжийг нь бүрдүүлж байгаа гэж харж байна. Миний мэдэж байгаагаар одоо энэ их дэлгүүрийн 5-р давхрын голын заал бараг хоосон байгаа. Тийм учраас хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ асуудлыг оруулаад хэлэлцэж байгаад бөөний түрээсийн загвараар явах нь зөв юм байна, компани маань урт хугацаанд өсөн дэвжихийн тулд, үнэ цэнээ хадгалахын тулд энэ нь зөв юм байна гээд хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ загварыг баталж шийдвэрлэж өгсөн байгаа. Үүний дагуу бид ажиллаад, ашиг орлогоо олоод явж байна. За мөн энд бас нэг түгээмэл асууж байгаа асуулт бол ногдол ашгийн асуулт байна. Бид мэдээж компанийг үр ашигтай ажиллуулж ашиг олж байгаад ногдол ашиг

тараах нэг загвар байж болж байна. Ногдол ашиг тараахаас гадна компанийн хувьцаа эзэмшигчдийн хүртдэг өгөөж бол хувьцааны нэгжийн үнэлгээ өсөх асуудал байгаа. Хэдхэн жилийн өмнө 300-400 төгрөг байсан хувьцаа өнөөдөр 3100 төгрөгийн үнэтэй болчихсон байгаа. Тэгэхээр 2, 3 хан жилийн дотор хувьцааны үнэ бараг 10 дахин өссөн байгаа. Өөрөөр хэлбэл та бүхний хөрөнгийн үнэ цэнэ өсчихөөд байна. Хувьцааны арилжаанд идэвхитэй оролцдог хүмүүс бол өсөлтийн үед нь яаж хөрөнгөө өсгөх үү, ямар үед нь зараад өөр ногдол ашиг өгдөг хувьцааруу хөрвүүлэх үү, эсвэл дахиад өсөлт хийдэг өөр компанируу шилжих үү гээд ийм хувилбаруудыг сонгоод явдаг. Үүнийг надаар хэлүүлэлтгүй та бүхэн мэдэж байгаа. Тэгэхээр энэ өгөөжийг хэдүүлээ зөв ойлголцох хэрэгтэй байна. Компания ашигтай ажиллуулахын төлөө ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс хэр хэмжээндээ хичээгээд ажиллаж байна. Сүүлийн 2-3 жилд компани дандаа ашигтай ажиллаж байна. Энэ бол бидний хичээж байгаа ажлын тодорхой үр дүн гэж харж байна. Нөгөөтээгүүр түрүүн хурлын танилцуулга дээр хэлсэн ногдол ашиг шалгуур үзүүлэлтийг Компанийн тухай хуулиар тодорхойлсон байдаг. Тэр хуулийг бид бас зөрчиж дураараа аашилж болохгүй. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд ногдол ашиг тарааж болох, болохгүй нөхцөлийг тусгасан байдаг. Хамгийн гол асуудал нь компанийн хувьцааны нэгжийн үнэлгээ тасралтгүй өсөж байна. Өөрөөр хэлбэл компани үнэ цэнэтэй болоод байна. Таны хувьцааны үнэ нэмэгдээд байна.

Хувьцаа эзэмшигч: Та нар худлаа яриад байна. 90 хэдэн онд 1 доллар хэдэн төгрөг байсныг мэдэх үү. Одоо 100 дахин үнэтэй болсон байна.

Хурлын дарга Я.Наваан: За би хувьцаа эзэмшигчдийнхээ асуултад хариулаад дуусгая. Тэгэхээр Компанийн тухай хуулийн дагуу бид ажиллаж байгаа. Хуулийн дагуу бол бид ногдол ашиг тараах боломж байхгүй. Тухайлбал Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, мөн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгөөс их байх гэсэн шаардлагууд тавигдсан байдаг. Өөрийн хөрөнгийн хэмжээг та бүхэн санхүүгийн тайлангаас харвал өөрийн хөрөнгийн хэмжээ нь эздийн өмчийн үнийн дүнгээс багассан алдагдалтай яваад байгаа учир ногдол ашиг хуваарилж болохгүй байгаа юм. Тэгэхээр энэ зөрүү алдагдлыг бид бууруулаад явж байна. Бид нэг жилийн дотор бүхэл бүтэн 1 тэрбум төгрөгөөр энэ зөрүү алдагдлыг бууруулж чадсан. Энэ нь бидний тодорхой хэмжээний ажлын үр дүн гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч А.Гандиймаа: Энэ их дэлгүүр яагаад тэгвэл алдагдалтай яваад байгаа юм бэ? Түрээсийн орлого аваад явж байгаа, 4 хөн ажилтантай байж яагаад 9 тэрбумын алдагдалтай явж байгаан бэ? Би энийг өнгөрсөн жил ч мөн асууж байсан. Би түрүүн асуусан тэр халаасны хувьцаа гэж юуг хэлээд байгаа юм бэ? 175 сая төгрөг юуны мөнгө вэ?

Хурлын дарга Я.Наваан: Компани зах зээлд нээлттэй хувьцаа гаргаад тухайн хувьцаанаасаа компани өөрөө эргүүлэн худалдаж авсан хувьцааг халаасны хувьцаа гээд байгаа юм. Хуулиар ийм боломжтой байдаг. Өнгөрсөн хугацаанд компани 1,683,139 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авч халаасласан байдаг. Энэ нь нэлээн дээр үед болсон процесс.

Хувьцаа эзэмшигч: Энэ халаасны хувьцаа нь ногдол ашигтай нэг их хамааралтай зүйл биш л дээ. Энийг манай хувьцаа эзэмшигчид бас ойлгох хэрэгтэй.

Хурлын дарга Я.Наваан: Би бол хувьцаа эзэмшигч та бүхний төлөөлөл. Хувьцаа эзэмшигчид цаагуураа хувьцаагаа хэрхэн яаж зарцуулах, шийдэхийг би мэдэхгүй. Хувьцаа эзэмшигчдээс хувьцааны үнийн талаар мэдээлэл авъя гэдэг асуулт бас ирсэн.

Хувьцаа эзэмшигч (Нэр тодорхойгүй): Наад асуудлууд чинь яахав бид ногдол ашгаа л авмаар байна. Та нар 30 жил өгсөнгүй. Одоо хувьцаагаа компанид өгсөн хэдэн байна.

Хурлын дарга Я.Наваан: Та бүхний энэ санал, асуултыг ойлгосон. Би ямартай ч хувьцаа эзэмшигчдийнхээ асуултад хариулт өгөөд дуусгадаахъя. Та бүхэн энэ хуралд ирсэн бусад хүмүүсээ бас хүндэтгэмээр байна. За компанийн түрээсийн үйл ажиллагаа, загварын хувьд ингээд бөөнөөр нь түрээслүүлээд явдаг байгаа. Компанийн үйл ажиллагаа бол сүүлийн 2-3 жилд үр ашигтай байгаа. Түрүүн ашиглалтын зардлуудыг юунд зарцуулсан бэ гэдэг асуулт орж ирсэн. Барилга засварын асуудлуудыг манай гүйцэтгэ захирал тайлбарлаад өгнө. Компанийн бүтэц орон тооны хувьд одоо 4 ажилтантай байгаа. Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Ахлах нягтлан бодогч, Нягтлан бодогч гээд 4 ажилтан байгаа. Барилгаа бүхлээр нь түрээслүүлдэг болохоор аль болох үр ашигтай ажиллах загвараар ингээд цөөн бүрэлдэхүүнээр ажиллаж байгаа. Эдгээр 4 ажилтны цалин хөлснөөс бодогдсон НДШ-ийн дүн болон татварын дүнгүүд санхүүгийн тайланд бичигдсэн байгаа дүн юм. Ер нь бол урт хугацаандаа олон компанийн санхүүгийн үйл ажиллагаа доголдоод Монгол Улсын олон аж ахуйн нэгж байгууллага хүндрэлтэй байгаа. Тэгэхэд манай компани ямар ч байсан үйл ажиллагаагаа тогтвортой сайжруулаад аваад явж байна. 2025 онд компани 1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Бизнес төлөвлөгөөнөөс бол нэлээд давж биелсэн. Шалтгаан нь бол та бүхэнд танилцуулж байсан. Засгийн газраас дулаан, цахилгааны үнийг нэмнэ гээд зарласан байсан. Ингээд цахилгааны үнэ бол нэмэгдээд явсан. Бид уг мэдэгдлийн дагуу дулааны үнэ бас нэмэгдэх юм байна гээд дулааны зардлаа нэмж төлөвлөсөн байсан. Гэтэл дулааны үнэ өсөөгүйгээс үүдэн 2025 онд дулааны төлөвлөсөн зардал хэмнэгдсэн. Мөн үндсэн үйл ажиллагаанаас гадна бид 2024 онд илүү орлоготой ажилласан, харин 2025 онд буурсан байна гэдэг санхүүгийн тайланг та бүхэн харж байгаа байх. Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн хяналт шалгалттай холбоотой асуулт та бүхэн асуусан. ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой тодорхой шийдвэрүүд гарч байсан. 2023, 2024 онуудад ТУЗ-ийн гишүүдээр зарим төлбөрүүдийг нөхөн төлүүлэх арга хэмжээг компани аваад Санхүүгийн зохицуулах хорооны тавьсан шаардлагыг нь бүрэн биелүүлсэн. Энэ биелүүлсэнтэй холбоотойгоор 2024 онд үндсэн бус үйл ажиллагааны 2.4 тэрбум төгрөг компанид орлогоор орж ирсэн. Түрээсийн орлого бол 11-ээс 2.7-г хасахаар 80.3 байсан байна. Тэр нь 9.3 болоод 2025 онд бүр нэмэгдсэн. Компанийн орлого 2024 онд илүү байсан бэ гэхээр түрүүн хэлсэн үндсэн бус үйл ажиллагааны орлого орж ирснээрээ 2025 оноос илүү байсан юм. Тэгээд 2025 онд орлого буурсан юм шиг харагдаад байгаа юм. Уг нь бол үндсэн үйл ажиллагаа буюу түрээсийн орлого бол жил бүр өсөөд явж байгаа. Компани жилээс жилд түрээсийн орлогоо нэмж байгаа. Түрээсийн орлого маань 9.3 тэрбум төгрөг байгаа. Нийтдээ 26,859 м.кв талбайг Номин реалтор ХХК-д түрээслүүлдэг. Энэ талбайг жилдээ 9.3 тб төгрөгөөр түрээслүүлээд явж байна.

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Түрээсийн үнийн өсөлтийн хувьд 2020 онд 8%, 2021 онд 15%, 2022 онд 10%, 2023 онд 10%, 2024 онд 10%, 2025 онд 7%-иар тус тус өсгөөд явж байгаа.

Хурлын дарга Я.Наваан: Сая гүйцэтгэх захирлын танилцуулсанчлан бид түрээсийн үнээ жил бүр ингээд өсгөөд явж байна. Гэтэл гадуур зах зээл ямар байгаа билээ. 100% бүх талбайгаа түрээслүүлээд үнээ өсгөөд явж чадаж байгаа юу. Маш их үйлчилгээний талбай шинээр баригдаж байна. Тэд бүгд ингэж ашигтай ажиллаж чадахгүй байгаа. Бид орлогоо тасралтгүй өсгөхийн төлөө ажиллаад явж байна. Түүний дагуу компанийн санхүүгийн үзүүлэлт ч гэсэн сайжраад явж байна.

Хувьцаа эзэмшигч: 1 м.кв талбайгаа хэдээр түрээслүүлж байгаа вэ?

Хурлын дарга Я.Наваан: 9.4 тб төгрөгийг 26,859 м.кв талбайдаа харьцуулахаар 1 м.кв талбайг жилдээ 349.9 сая төгрөгөөр түрээслүүлж байна. Үүн дээр дахиад хэлэхэд бид бөөний түрээс буюу барилгаа бүхэлд нь түрээслүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл тэнд жижиглэн лангууны үнэ манай түрээсийн үнэд нөлөөлөхгүй. Тэр лангуу хоосон байна уу хүнтэй байна уу хамаагүй бид Номин реалтор ХХК-иас авдаг мөнгөө аваад л явж байгаа. Ашиггүй талбай буюу шат, хонгилын талбайгаас хүртэл мөнгө авч байгаа. Шинэ тутам нээгдэж байгаа худалдааны төвүүд бол эдийн засгийн хувьд хүндрэлтэй, хоосон талбай зөндөө сууж байгаа. Энэ нөхцөл байдлыг хараад хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ бөөний түрээсийн загвар дэмжигдээд батлагдсан байдаг. Өмнөх жилүүдийн хурлууд дээр бас энэ асуудлыг дэлгэрэнгүй ярьж байсан. За хурлын ирцийн талаар бас асуусан байна. Хурлын эхэнд танилцуулсан. Хурлаас өмнө саналаа урьдчилан бичгээр буюу саналын хуудсаар өгсөн 58 хүн байгаа. Онлайнаар бас хэдэн хүн оролцож байна. Мөн зааланд биечлэн ирээд оролцож байна. Ингээд эдгээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй нийт хувьцааны тоо нь компанийн нийт хувьцааны 70.5%-ийг эзэлж байна гэсэн тоог танилцуулсан. Тиймээс хурлын ирц хүчин төгөлдөр болж байгаа юм. Тухайлбал компанийн том хувьцаа эзэмшигч нар урьдчилан бичгээр санал өгч хурлын ирцийн дийлэнх хувийг бүрдүүлсэн. За мөн Улсын их дэлгүүр дээрээ хурлаа хийж байя гэсэн санал гаргасныг дэмжиж байя. Дараагийн хурлаа дэлгүүр дээрээ зохион байгуулж болно. Мөн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн талаар асуусан. Одоо ТУЗ-ийн хараат бус гишүүдээр Ганцэцэг, Энхчимэг, Дамирансүрэн гээд 3 гишүүн ажиллаж байгаа. Эдгээр гишүүд нь хууль эрх зүйн чиглэлийн мэргэжлийн хүмүүс байгаа. Эдгээр хараат бус гишүүдийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгосон бөгөөд нээлттэй сонгон шалгаруулалтын хүрээнд нэр дэвшүүлж сонгуулсан. Телевиз, сонин сэтгүүл дээр сонгон шалгаруулалтын зар явуулаад тодорхой тооны нэр дэвшигчид дундаас эдгээр хүмүүс нэр дэвшиж сонгогдсон. Мөн ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангаад, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдөөд сонгогдсон хүмүүс юм. Харин ТУЗ-ийн гишүүд хувьцаа эзэмшигчдийн хуралд зайлшгүй оролцох үүргийг хуулиар хүлээдэггүй. ТУЗ-ийн гишүүдээ төлөөлөөд өнөөдрийн хурал дээр ТУЗ-ийн дарга Наваан миний бие оролцоод асуудлаа танилцуулж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Урьдчилсан саналын процессыг та бүхэнд товчхон танилцуулъя. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд урьдчилж 58 хүн саналын хуудсаар санал өгсөн. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 4 сарын 3-ны өдрөөр тасалсан. Тэгээд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 4 сарын 10-ны өдөр үнэт цаасны эзэмшигчдийн судалгааг хүлээж авсан. Энэ өдрөөс хойш хуралд биечлэн оролцож чадахгүй гэсэн хүмүүс урьдчилж надтай уулзаад хэлэлцэх асуудлаар урьдчилан саналын хуудсаар саналаа өгөөд явсан. Хамгийн сүүлд өчигдөр буюу 4 сарын 22-ны өдөр сүүлийн хүмүүс саналаа өгөөд явсан. Эдгээр саналаа өгсөн хүмүүсийн хэд нь зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн санал өгсөн бэ гэдэг нь санал хураалтын дараа нэгтгэгдээд танилцуулагдана. Ер нь бол урьдчилан санал өгсөн хүмүүс хурлаар хэлэлцэж буй 2 асуудлыг зөвшөөрсөн санал өгсөн байгаа.

Хувьцаа эзэмшигч Батсүрэн /онлайнаар/: Санхүүгийн тайлан дээрх өртөг үнэ 5.5 тб төгрөг дээр тайлбар өгнө үү.

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Энэ өртөг дээр байгаа дүнгүүд нь барилгын ашиглалт үйлчилгээтэй холбоотой зардлууд бичигдсэн байгаа.

Хурлын дарга Я.Наваан: 2024 онд ерөнхий ба удирдлагын зардал дээр бичигддэг байсан ашиглалтын зардлуудыг хөндлөнгийн Аудитын компани болох Сүлд-Аудит ХХК-иас өгсөн зөвлөмжийн дагуу өртөгрүү шилжүүлж бичсэн. 2025 онд доороосоо дээшээ шилжсэн өртөг юм. Өөрөөр хэлбэл нягтлан бодох бүртгэлийн бичилттэй холбоотой асуудал юм.

За ингээд хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх 2 асуудалтай холбоотой танилцуулга хийгдэж, хувьцаа эзэмшигч нар санал, хүсэлтээ хэлж асуултаа асууж дууслаа. Тэгээд одоо та бүхэн өөрсдийн итгэл үнэмшлээр хэлэлцэж буй асуудлуудад саналаа өгөх ёстой байгаа. Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч нарт саналын хуудсыг тарааж өгөөд саналын хуудас бөглөх зааварчилгаа өгөөд явна уу. Санал хураалтын үйл ажиллагааг 20 минутын хугацаанд хийж дуусгаад саналаа нэгтгэе.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Цахимаар оролцож байгаа хүмүүсийн бүртгүүлсэн и-мэйл хаягруу санал хураалтын линк явуулах болно. Та бүхэн тухайн линкээр орж саналаа бөглөөд дуусгах товчийг дарах ёстой.

Тооллогын комисс: Хувьцаа эзэмшигч нарт цаасаар саналын хуудас тарааж өгнө. Саналын хуудсыг буруу бөглөсөн болон засварласан тохиолдолд дахин 1 удаа саналын хуудас авч дахин бөглөх боломжтой. (гээд Тооллогын комиссын гишүүд саналын хуудсыг хэрхэн бөглөх болон кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох зарчмыг тайлбарлан өгөв)

Хурлын дарга Я.Наваан: За хурлаар хэлэлцсэн асуудлууд дээр хувьцаа эзэмшигчид саналаа өгч дууссан байна. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Өсөхбаяр: Санал хураалтын дүнг танилцуулъя. Энд хувь хүний нууцтай холбоотой асуудал яригддаг учраас хувьцаа эзэмшигчийн нэрийг дурдахгүйгээр санал хураалтын үр дүнг танилцуулах ёстой гэдгийг урьдчилж хэлье.

1-р асуудал буюу Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах асуудалд 25,953,756 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.981% нь зөвшөөрсөн, 2171 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.008% нь татгалзсан, 2589 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.010% нь санал өгөөгүй түдгэлзсэн байна.

2-р асуудал буюу ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах асуудалд 25,953,897 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.982% нь зөвшөөрсөн, 1855 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.007% нь татгалзсан, 2755 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.011% нь санал өгөөгүй түдгэлзсэн байна.

Хурлын дарга Я.Наваан: Санал хураалтын үр дүнтэй танилцлаа.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.981 хувийн саналаар зөвшөөрсөн тул уг асуудал батлагдлаа.

ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.982 хувийн саналаар зөвшөөрсөн тул зардлын төсөв батлагдлаа.

За санал хураалтын үр дүн тодорхой болсон учир та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг уншиж танилцуулъя. (гээд дараах төслийг танилцуулав)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04-р сарын 23-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04-р сарын 23-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоолын хавсралтаар батлагдсан цалин хөлсийг зохих журмын дагуу олгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлыг энэхүү тогтоолын хавсралтад заасан төсөвт багтаан гаргах, зардлын зарцуулалтыг компанийн санхүүгийн тайлан тэнцэлд зохих журмын дагуу бүртгэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал болон Ахлах нягтлан бодогч нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НАВААН

Ингээд хурлын үйл ажиллагааг дуусгая. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 13:00 цагт дуусав.

ТЭМДЭГЛЭЛИЙГ ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ХУРЛЫН ДАРГА



Я.НАВААН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ӨЛЗИЙБАТ